

Сонгогчдын хүсэж буй улсын их хурлын гишүүний дүр төрхийн судалгаа

Пүрэвдоржийн Түмэнцэцэг *

МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн докторант
Улаанбаатар, Монгол Улс
tumentsetseg1121@gmail.com

Дагва-Очирын Бумдарь

Доктор (Ph.D), профессор
МУИС-ийн Улс төр судлалын тэнхим
Улаанбаатар, Монгол Улс
bumdari@num.edu.mn

Баярмагнайн Баярбаатар

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн
докторант
Улаанбаатар, Монгол Улс
b_bayar8888@yahoo.com

Хураангуй

УИХ-д сонгохыг хүсэж байгаа улс төрчийн дүр төрхийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийлээ. Улс төрчийн дүр төрхийг тодорхойлохдоо боловсролын түвшин, мэргэжил, ур чадвар, зан чанар, хүйс, нас, үндэс угсаа, зан чанар, гадаад төрх, шашин шүтлэг, гэр бүлийн байдал зэрэг хүчин зүйлүүдээр судалсан болно. Судалгаанд Баянгол дүүргийн 18 болон түүнээс дээш насны нийт 500 хүнийг (эрэгтэй 49 хувь, эмэгтэй 51 хувь) 2023.4.21-2023.4.23-ны өдрүүдэд хамруулж мэдээлэл цуглуулсан.

Судалгаанд улс төрчийн дүр төрхийг тодорхойлох анкетын арга болон хоёрдогч тоон мэдээлэлд анализ хийх аргыг ашиглав. Ур чадварын хувьд манлайлагч, нөхцөл байдлыг хурдан ойлгож, хариу өгөх чадвартай, улс төрийн шийдвэрийг мэргэжлийн түвшинд гаргадаг, задлан шинжилж, дүгнэх чадвартай байх. Зан чанарын хувьд үнэнч, шударга, амлалтдаа хүрдэг, нийтийн сайн сайхны төлөө гэсэн сэтгэлтэй байх. Гадаад төрхийн хувьд эрүүл чийрэг, зөв царайны төрхтэй, монголжуу царайтай, зөв хувцасладаг байх. Гишүүнээр сонгогдож байгаа хүний гэр бүлийн хүн нь заавал Монгол байх, гишүүн болох гэж байгаа хүний намын харьяалал чухал биш, тодорхой түвшний орлого, хөрөнгөтэй байх шаардлага гэж судалгааны үр дүнгээс гарсан юм. Дээрх нийтлэг үр дүн нь УИХ-д сонгогдох эрэгтэй, эмэгтэй гишүүний хувьд ялгаатай болох судалгаагаар гарсан болно.

Түлхүүр үгс: *УИХ-д сонгогдох гишүүний нас, хүйс, боловсрол, мэргэжил, зан чанар, гадаад төрх, үндэс угсаа, шашин шүтлэг*

* The Corresponding author



© The Author(s) 2023

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

<https://orcid.org/0009-0004-4729-4883>

<https://orcid.org/0000-0002-8614-3891>

<https://orcid.org/0009-0009-6368-1716>

Received: 30 August 2023

Accepted: 27 October 2023

Research on the image of a member of the State Great Khural who desired by voters

Tumentsetseg Purevdorj*

*Ph.D candidate student, Department of Sociology & Social Work
National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia
tumentsetseg1121@gmail.com*

Bundari Dagva-Ochir

*Doctor (Ph.D)
Department of Political Science
National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia
bundari@num.edu.mn*

Bayarbaatar Bayarmagnai

*Ph.D candidate student
Department of Political Science
National University of Mongolia
b_bayar8888@yahoo.com*

Abstract:

The study was aimed at determining the profile of politicians wishing to be elected to parliament. In determining the image of politicians, factors such as education, profession, skills, personality, sex, age, ethnic origin, personality, appearance, religion and marital status are studied. The survey consisted of 500 people aged 18 in Bayangol (49 per cent males and 51 per cent females) and collected data from 21.04.2023 to 23.04.2023. The survey used questionnaires to determine politicians' image and analyse secondary quantitative data. As far as skills, leadership, ability to quickly understand and respond to situations, professional political decision making, analysis and evaluation is concerned. Be honest, fair, reaffirm your commitment and seek public interests. As far as appearance is concerned, it should be healthy, with right facial features, Mongolian face and proper clothing.

The results of the study showed that the family member of the person elected to be a member of parliament should be Mongolian, and the party affiliation of the person who is going to be a member does not matter, but it is necessary to have a certain level of income and assets. The overall results above are from the study of the differences between male and female MPs.

Keywords: *age, gender, education, profession, character, appearance, ethnicity, religion of the member of parliament to be elected*

I. Оршил

Сонгогчид сайн төлөөлөлтэй байхын тулд “Сонгогч-улс төрчийн нийцэл”-ийн зарчмыг баримтлахаас гадна судлаач Мондакын боловсруулсан “Манлайлагчийн бие хүний онцлогууд” гэсэн зарчмыг ашигладаг байна. Өөрөөр хэлбэл улс төрч, манлайлагч хүнд байх ёстой онцлог шинжүүд байгаа эсэхээр нь сонголтоо хийдэг гэжээ. Сонгогчид оюуны өндөр чадавх, төсөөлөл буюу шинэ санаанд нээлттэй, жинхэнэ сэхээтэн, ухаалаг, мэдлэг мэдээлэл сайтай улс төрчийг, манлайлагчийг

шаарддаг. Харин эсрэгээрээ “ойворгон” хэв шинжийг манлайллын муу шинж гэж үздэг болохыг тогтоожээ.

Сонгогчид “тогтворгүй”, “найдваргүй”, “хааш яаш” эсвэл “олигархуудтай харьцдаг”, “ёс суртахууны доголдолтой” шинж чанаруудыг сонгуулийн үеэр хүлээн зөвшөөрдөггүй. Харин эсрэгээрээ судалгаанд оролцогчид “шударга”, “итгэл даахуйц” байдлыг манлайллын маш чухал шинж чанар гэж үзсэн. Үүнтэй адилаар судлаач Киндэр (Kinder, 1980) “эрх мэдэлд шунамтгай”, “тогтворгүй” байдал нь манлайллын хамгийн сөрөг шинж бол “үнэнчшударга” байдал нь хамгийн эерэг хэв шинж гэж сонгогчид тооцдог гэжээ. Сонгогчид УИХ-ын сонгуульд санал өгөхдөө нам гэхээс илүүтэй хувь хүнийг харсан сонголт хийдэг бол сонголтод нөлөөлөгч дараагийн чухал үзүүлэлт нь оршин суугаа газрын хамааралтай байгааг Стратеги Академиас сар бүр хийдэг “Нийгэм, улс төр, эдийн засгийн байдлын талаарх олон нийтийн санаа бодол” (Стратеги академи 2021; 2022) судалгааны 2021 оны 11 сараас 2022 оны 08 сар хүртэлх 10 удаагийн үр дүнг харуулж байна. Судалгаагаар 2 хүн тутмын нэг нь УИХ-ын гишүүнийг сонгохоор санал өгөхдөө улс төрийн намын харьяаллаас илүүтэй хувь хүнийг нь харсан сонголт хийнэ гэж хариулжээ. “Монгол сонгогчийн зан үйл: нөлөөлөгч хүчин зүйлс, өөрчлөлт” (П.Түмэнцэцэг 2022) судалгаагаар сонгогчдын оршин суугаа газар нь сонголтод шууд байдлаар нөлөөлдөг болох нь батлагдсан байна.

Бид энэхүү судалгааг Баянгол дүргийн сонгогчид өөрийг нь төлөөлж УИХ-д гишүүн болох хүний дүр төрхийг хэрхэн төсөөлж байгааг тодорхойлох зорилгоор хийлээ. Улс төрчийн дүр төрхийг нас, хүйс, боловсрол, мэргэжил, ур чадвар, үндэс угсаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдал, гадаад төрх, зан чанар, хөрөнгө орлого, гэр бүлийн байдал зэрэг үзүүлэлтээр тодорхойлов.

II. Судалгааны арга зүй

Судалгааны түүвэрлэлт хийхдээ буцаалтгүй, энгийн санамсаргүй түүврийг ашиглаж, дараахь томъёогоор түүврийн хэмжээг тооцсон болно. Ингэхдээ 95.4 хувийн итгэлтэйгээр, алдааны хязгаар ± 5 хувиас илүү зөрөхгүй байхаар тооцоход Баянгол дүүргийн 18-аас дээш, сонгуулийн насны иргэдийг 399 төлөөлөхөөр байсан.

$$n = \frac{t^2 \cdot w \cdot (1 - w) \cdot N}{N \cdot \Delta_p^2 + t^2 \cdot w \cdot (1 - w)}$$

Бид дээрх тооцоололд үндэслэн, түүврийн тоог тодорхой хэмжээнд нэмэгдүүлж, Баянгол дүүргийн 18 болон түүнээс дээш насны нийт 149,651 хүний төлөөлөл болгож 500 хүнийг (эрэгтэй 49 хувь, эмэгтэй 51 хувь) хамруулсан. Судалгаанд анкет, хоёрдогч тоон мэдээлэлд анализ хийх аргыг ашиглаж, судалгааны боловсруулалтыг SPSS 26, Excel программыг ашиглаж хийсэн.

III. Судалгааны үр дүн

УИХ-д сонгогдох гишүүнд тавигдах шаардлага. Судалгаанд оролцогчдын 62.8% буюу хамгийн багадаа 2 хүн тутмын нэг нь УИХ-ын гишүүн байх хүнд боловсролын түвшин хамгийн чухал гэжээ. Түүний дараахь чухал хүчин зүйлүүдээр ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, зан чанар зэргийг нэрлэжээ. УИХ-ын гишүүнд тавигдах шаардлагыг уг судалгааны хүрээнд заавал ач холбогдлоор нь дараалуулах шаардлагатай байсан тул судалгаанд оролцогчдоос хамгийн чухал гэсэн 3 хүртэл сонголт хийлгэсэн. Гэхдээ үзүүлэлт тус бүрээр авч үзэх тохиолдолд чухалд тооцогдох магадлал бүхий хүчин зүйлс байгааг анхаарах нь зүйтэй. Тухайлбал, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хийсэн “Мэдрэмжтэй мэдээлэл” (Хэвлэл мэдээллийн зөвлөл 2021) судалгаагаар улс төрийн мэдээллээр гаргаж буй 10 эх сурвалжийн нэг нь л эмэгтэй байдаг. Эмэгтэй улс төрчдийг мэдээгээр гаргахдаа гэр бүлийн байдал, өмссөн хувцас, гадна үзэмж, харагдах байдал зэргээр шүүлтүүр тавьж, шүүмжлэх хандлага их байна гэсэн дүгнэлт гарсан.

“Жендер, улс төр ба мэдээ: Гурван талын тоглоом” номын зохиогч, профессор Карен Росс хэлэхдээ “эмэгтэй хүн ээж байна уу, улс төрч байна уу, загвар өмсөгч байна уу хамаагүй, эхний ээлжид тэднийг биологийн хүйсээр нь, дараа нь биеэ авч явах байдлаар нь, зөвхөн үүний дараа л мэргэжлийн албан тушаалынх нь дагуу загварчлан гаргадаг” гэж хэлсэн байдаг.

Зураг 1. УИХ-ын гишүүн хүнд байх хамгийн чухал үзүүлэлт




Тайлбар: Нэг хүн 3 хүртэлх хариулт өгсөн тул нийлбэр 100% барихгүй болохыг анхаарна уу.

УИХ-ын гишүүн хүнд тавигдах шаардлагыг судалгаанд оролцогчдын хүйс, насны бүлгээр харьцуулж харуулахад дараахь үр дүн гарав.

Хүйсийн хувьд:	- Эмэгтэй сонгогчид боловсролын түвшин, ажлын туршлагыг; - Эрэгтэй сонгогчид мэргэжлийн ур чадвар, зан чанарыг УИХ-ын гишүүн хүнд зайлшгүй байх ёстой гэж тус тус хариулсан байна.
Насны хувьд:	18-24 настай сонгогчид боловсролын түвшин, мэргэжлийн ур чадварыг чухалд тооцож буй нь хамгийн өндөр үзүүлэлт байлаа.

Сонгогчдын нас нэмэгдэх тусам боловсролын түвшин, ажлын туршлага, мэргэжлийн ур чадварыг чухалчлах байдал буурч, зан чанарт ач холбогдол өгөх байдал нэмэгдэж байна. УИХ-ын гишүүн байх хүнд боловсролын түвшин чухал гэж судалгаанд оролцогч эмэгтэйчүүд, насны бүлгээр харьцуулж харвал 18-32 насныхан илүүтэй чухалчилжээ. УИХ-ын гишүүн хүнд ажлын туршлага чухал гэж судалгаанд оролцогчдын 42.4% нь хариулсан. Тус хариултыг судалгаанд оролцогчдын хүйсээр харьцуулж харвал эмэгтэйчүүд, насны бүлгээр харьцуулж харвал 25-48 насныхан илүүд үзэж байна.

Зураг 2. УИХ-ын гишүүн хүнд байх хамгийн чухал үзүүлэлт (насны бүлэг, хүйсээр)




Тайлбар: Нэг хүн 3 хүртэлх хариулт өгсөн тул нийлбэр 100% барихгүй болохыг анхаарна уу.

Мэргэжлийн ур чадварын тухайд судалгаанд оролцогчдын 34.4% буюу 3 хүн тутмын нэг нь чухал гэж үзсэн. Тус хариултыг судалгаанд оролцогчдын хүйсээр харьцуулж харвал эрэгтэйчүүд, насны бүлгээр харьцуулж харвал 18-40 насныхан чухал гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын 20.4% нь УИХ-ын гишүүн хүнд зан чанар чухал гэж хариулсан. Тус хариултыг судалгаанд оролцогчдын хүйсээр харьцуулж харвал эрэгтэйчүүд, насны бүлгээр харьцуулж харвал 18-24, 49-өөс дээш насныхан илүүтэй чухалд тооцсон байна (Зураг 2).

Сонгохыг хүсэж буй УИХ-ын гишүүний хүйс (эрэгтэй/эмэгтэй). 1992 оноос 2020 он хүртэлх нийт 8 удаагийн УИХ-ын сонгуульд Баянгол дүүрэгт нийт 214 улс төрч нэр дэвшиж байжээ. Үүнээс 19% нь эмэгтэй, 81% нь эрэгтэй нэр дэвшигч байсан байна. Тус дүүргээс нийт 27 хүн УИХ-д гишүүнээр сонгогдсон. Үүнээс 15% нь эмэгтэй, 85% нь эрэгтэй байна. Сонгогчдын 4 хүн тутмын нэг нь эрэгтэй, 5 хүн тутмын нэг нь эмэгтэй байх нь оновчтой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл эрэгтэй хүн УИХ-ын гишүүн байх нь оновчтой гэх хандлага арай илүү байдаг аж. Эмэгтэй сонгогч эмэгтэйчүүдээ, эрэгтэй сонгогч эрэгтэйчүүдээ УИХ-ын гишүүн байх нь оновчтой гэж үзэж, дэмждэг аж. Эрэгтэй сонгогч эмэгтэйчүүдийг УИХ-ын гишүүн байх нь оновчтой гэж хариулсан дүн эмэгтэй сонгогч эрэгтэйчүүдийг УИХ-ын гишүүн байх нь оновчтой гэж хариулсан дүнгтэй харьцуулахад бараг 2 дахин өндөр байгааг Зураг 3-аас харна уу. 18-24 нас, 41-ээс дээш насныхны хариултаас харвал эрэгтэй хүн УИХ-ын гишүүн байх нь оновчтой, эмэгтэй хүн УИХ-ын гишүүн байх нь оновчтой гэж хариулсан дүн ойролцоо буюу төдийлөн ялгаагүй байна.

Зураг 3. УИХ-д байх гишүүний хүйс (эрэгтэй/эмэгтэй) ба нас (Сонгогчдын хүйсээр болон насны бүлгээр)




18-24 нас, 33-40 насныхны 63%-64% УИХ-д сонгогдох хүн нь ямар хүйсийнх байх нь чухал биш гэж хариулсан нь бусад насныхантай харьцуулахад өндөр байна. Тус хариултыг сонгосон дүнгээс харвал насны бүлгээс үл хамааран хамгийн багадаа 2 хүн тутмын нэг нь УИХ-ын гишүүн эрэгтэй эсвэл эмэгтэй хүйстэй байна гэдэгт ач холбогдол өгдөггүй болох нь харагдлаа.

Сонгохыг хүсэж буй УИХ-ын гишүүний нас: 1992 оноос 2020 он хүртэлх нийт 8 удаагийн УИХ-ын сонгуульд Баянгол дүүрэгт нийт 214 улс төрч нэр дэвшиж байжээ. Үүнээс 18% нь 25-35 настай, 46% нь 36-45 настай, 26% нь 46-55 настай, 10% нь 56-аас дээш настай байсан байна. Тус дүүргээс нийт 27 хүн УИХ-д гишүүнээр сонгогдсон. Үүнээс 7% нь 25-35 настай, 56% нь 36-45 настай, 22% нь 46-55 настай, 15% нь 56-аас дээш настай байсан байна. Эндээс харахад, УИХ-ын сонгуулиар Баянгол дүүрэгт нэр дэвшсэн хүмүүсийн 46% нь 36-45 настай байсан

бөгөөд сонгогдсон нь нийт гишүүдийн 56%-ийг эзэлж байна. Мөн нэр дэвшсэн хүмүүсийн 26% нь 46-55 настай байсан бол сонгогдсон 22% нь, 56-аас дээш настай нэр дэвшсэн хүмүүс 10% байсан бол сонгогдсон нь 15% байна.


Манай судалгаагаар, УИХ-ын гишүүн 36-55 настай байвал оновчтой гэж үзэж байна. Сонгогчдын хүйсийн ялгаатай байдлаар харвал УИХ-ын эмэгтэй гишүүнийг 36-45 настай, УИХ-ын эрэгтэй гишүүнийг 46-55 настай байх нь зохимжтой гэжээ. УИХ-ын гишүүн болоход хамгийн тохиромжтой нас нь 36-45 нас гэж ерөнхийд нь дүгнэж байна. УИХ-ын эмэгтэй гишүүн нь 36-45 настай, эрэгтэй гишүүн нь 46-55 настай байвал тохиромжтой гэж судалгааны үр дүнгээс гарлаа.

Зураг 4. УИХ-д байх гишүүний нас (Сонгогчдын насны бүлгээр)



Судалгаанд оролцогчдын насны бүлгээр тус дүнг харьцуулж харвал, 18-40 настай сонгогчид УИХ-ын гишүүний насыг 36-45 нас, 41-ээс дээш насныхан 46-55 нас байвал зохимжтой гэжээ. Харин 25-35 настай хүнийг УИХ-ын гишүүнээр сонгоно гэж 18-32 настай залуучууд хариулсан нь бусад насныхантай харьцуулахад өндөр байна.

Зураг 5. Баянгол дүүргийн сонгуулийн насны хүн ам



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо, 2021 он


1992-2020 онд УИХ-ын сонгуульд нэр дэвшигч, сонгогдсон гишүүдийн мэдээлэл, тус дүүргийн сонгогчдын насны бүлэг, сонгуулийн идэвх болон судалгаанд оролцогчид гишүүнээр сонгох хүнийхээ насанд хэрхэн ач холбогдол өгч байгаагаас харвал, 36-55 настай хүн УИХ-ын гишүүнээр сонгогдох магадлал өндөр байна.

18-40 настай сонгогч 36-45 настай хүнийг УИХ-ын гишүүнээр сонгох, 41-ээс дээш насныхан 46-55 настай хүнийг сонгох магадлал өндөр байгаа юм. Тодруулбал, нийт сонгуулийн насны хүн амд эзэлж буй дүнгээрээ 18-40 настай хүн, 41-ээс дээш настай хүний тоо ойролцоо боловч, 18-40 настай хүмүүсийн сонгуулийн идэвх, оролцоо сул байгаа нь УИХ-ын сонгуулийн шийдвэрлэх мөчид 41-ээс дээш настай сонгогчийн санал хамгийн их нөлөө үзүүлэх болохыг харуулж байна. Хэрвээ 25-35 настай залуу хүн тухайн дүүрэгт нэр дэвшвэл сонгогдох магадлал маш бага болохыг анхаарах нь зүйтэй.

УИХ-д байх гишүүний боловсрол, мэргэжил, ажлын туршилага, ур чадвар. Боловсролын хувьд, 1992 оноос 2020 он хүртэлх нийт 8 удаагийн УИХ-ын сонгуульд Баянгол дүүрэгт нийт 214 улс төрч нэр дэвшиж, 27 нь УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Нэр дэвшсэн улс төрчдийн 75% нь буюу 4 хүн тутмын 3 нь, УИХ-д сонгогдсон гишүүдийн 89% нь нь бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байна. Судалгаанд оролцогчдын 62.8% нь УИХ-ын гишүүний боловсролын түвшин чухал гэж хариулсан. Үүнээс магистр болон докторын зэрэгтэй байх гэж судалгаанд оролцогчдын 40%-50% буюу ойролцоогоор 2 хүн тутмын нэг нь хариулсан нь хамгийн өндөр дүн байна. Харин 4 хүн тутмын нэг нь бакалавр байх нь оновчтой гэжээ.

УИХ-ын эмэгтэй гишүүн магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх нь чухал гэж хариулсан эрэгтэй гишүүнд тавигдах шаардлагаас өндөр байна. Өөрөөр хэлбэл, эмэгтэй гишүүний боловсролын түвшин, эрэгтэй гишүүний боловсролын түшингээс илүү чухалд тооцогдож байна (Зураг 6).

Зураг 6. УИХ-д байх гишүүний боловсрол



Тайлбар: Нэг хүн 3 хүртэлх хариулт өгсөн тул нийлбэр 100% барихгүй болохыг анхаарна уу.

Эндээс дүгнэхэд, Баянгол дүүргийн иргэд сонголт хийхдээ боловсролын зэрэгт өндөр ач холбогдол өгч, хамгийн багадаа бакалаврын зэрэгтэй хүнийг УИХ-ын гишүүнээр сонгодог, тухайн нэр дэвшигчийн боловсролын зэрэг нэмэгдэж магистр,


доктор болох тусмаа сонгогдох магадлал нэмэгддэг болохыг харуулж байна. 1992 оноос 2020 он хүртэлх нийт 8 удаагийн УИХ-ын сонгуульд Баянгол дүүрэгт нийт 214 улс төрч нэр дэвшиж, 27 нь УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Нэр дэвшсэн улс төрчдийн 60% нь буюу 10 хүн тутмын 6 нь, сонгогдсон УИХ-ын гишүүдийн 70% буюу 10 хүн тутмын 7 гадаадад суралцаж, боловсрол эзэмшиж байжээ. УИХ-ын гишүүн хаана боловсрол эзэмшсэн байх нь чухал биш гэж судалгаанд оролцогчдын 59% буюу 10 хүн тутмын 6 нь хариулжээ. Харин УИХ-ын гишүүн эрэгтэй, эмэгтэй байхаас хамаарч тус дүн ялгаатай байна. УИХ-ын эрэгтэй гишүүн хаана боловсрол эзэмшсэн нь чухал биш гэж судалгаанд оролцогчдын 45%, эмэгтэй гишүүний хувьд 33% нь хариулжээ. Боловсрол эзэмшсэн газарт ач холбогдол өгч байгаа сонгогчид Монголд гэхээс илүүтэй гадаадад боловсрол эзэмшсэн байх нь зохистой гэж үзэж байна.

1992-2020 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн болон гишүүнээр сонгогдсон хүмүүсийн боловсрол эзэмшсэн газар, тус дүүргийн иргэдийн тавьж буй шалгуур үзүүлэлтээс харвал, гадаадад боловсрол эзэмшсэн хүнийг УИХ-ын гишүүнээр сонгох магадлал өндөр байна.

Ерөнхийд нь дүгнэвэл тухайн дүүргийн сонгогчид өөрсдийг нь төлөөлж сонгогдох УИХ-ын гишүүн гадаадад боловсрол эзэмшсэн байх нь оновчтой гэсэн байр суурийг илэрхийлж байна.

Мэргэжил: 1992 оноос 2020 он хүртэлх нийт 8 удаагийн УИХ-ын сонгуульд Баянгол дүүрэгт нийт 214 улс төрч нэр дэвшиж, 27 нь УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Нэр дэвшсэн улс төрч болон сонгогдсон УИХ-ын гишүүдийн мэргэжлээс харвал эдийн засагч, хуульч, инженерүүд хамгийн их жин дарж байгаа бол олон улсын харилцаа, удирдахуй ухааны чиглэлийн хүмүүс удаах чухал мэргэжилд орж байна.

Зураг 7. 1992-2020 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигч болон сонгогдсон гишүүдийн мэргэжил



Эх сурвалж: 1992-2020 онд Баянгол дүүрэгт нэр дэвшсэн улс төрчдийн тоон мэдээлэл

УИХ-ын гишүүн нь хуульч, эдийн засагч, улс төр судлаач зэрэг мэргэжилтэй байх шаардлагатай гэж судалгаанд оролцогчдын 30%-40% буюу ойролцоогоор 3 хүн тутмын нэг нь хариулсан нь хамгийн өндөр дүн байна. УИХ-ын эрэгтэй

гишүүн нь улс төр судлаач, инженер, физик математикч, эмэгтэй гишүүн олон улсын харилцаа судлаач, багш мэргэжилтэй байх нь оновчтой гэжээ.

1992-2020 онд УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн болон сонгогдсон гишүүдийн мэргэжил, Баянгол дүүргийн иргэдийн мэргэжилд ач холбогдол өгч буй байдлаас харвал хуульч, эдийн засагч, олон улсын харилцаа, улс төр судлаач, инженерүүд сонгогдох магадлал хамгийн өндөр байна. Нэг сонирхолтой дүр зураг бол өнгөрсөн сонгуулиудад нэр дэвшиж, сонгогдсон хүмүүс дунд улс төр судлаач мэргэжилтэй хүн харьцангуй цөөн байсан ч өнөөдөр тус мэргэжлийн хүн УИХ-д байх ёстой гэж үзэх сонгогчдын тоо өссөн дүнтэй байна.


Ажлын туриллага: УИХ-ын гишүүнд ажлын туршлага чухал гэж судалгаанд оролцогчдын 42.4% нь хариулжээ. Тодруулбал, нийгэм, эдийн засаг, улс төр, хууль зэрэг салбарын олон талын мэдлэгтэй байх, мэргэжлээрээ олон жил ажилласан байх нь чухал гэж судалгаанд оролцогчдын 40%-50% буюу ойролцоогоор 2 хүн тутмын нэг нь хариулсан нь бусад туршлагатай харьцуулахад хамгийн өндөр нь байна. УИХ-ын эмэгтэй гишүүн бизнесийн байгууллагад ажилласан байх, эрэгтэй гишүүн эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр ажилласан байх шаардлагатай гэж судалгаанд оролцогчид хариулжээ.

Ур чадвар: Судалгаанд оролцогчдын 34.4% буюу 3 хүн тутмын нэг нь ур чадварыг чухал үзүүлэлт гэж үзсэн. УИХ-ын гишүүн нь манлайлагч, нөхцөл байдлыг хурдан ойлгож, хариу өгөх чадвартай, улс төрийн шийдвэрийг мэргэжлийн түвшинд гаргадаг, задлан шинжилж, дүгнэх чадвартай байх нь чухал гэж 4-5 хүн тутмын нэг нь хариулсан нь бусад ур чадвартай харьцуулахад өндөр дүнтэй байна. УИХ-ын эмэгтэй гишүүнд шуурхай шийдвэр гаргадаг, багийн гишүүдээ сонсдог, хийсэн ажлаа олон нийтэд хүргэдэг чадвартай байх, эрэгтэй гишүүн нь ажил хийх хүсэл эрмэлзэлтэй байх, шинийг санаачлагч байх, хувийн сэтгэл хөдлөлдөө баригддаггүй байх зэрэг чадвартай байх хэрэгтэй гэж судалгааны үр дүнгээс гарлаа.

УИХ-д байх гишүүний үндэс, угсаа

Ойролцоогоор 2 хүн тутмын нэг нь УИХ-ын гишүүн ямар үндэс, угсаатай байх нь чухал биш гэсэн байр суурийг илэрхийлж байгаа бол тал хувь үндэс, угсаанд ач холбогдол өгч байна. УИХ-ын гишүүний үндэс, угсаанд ач холбогдол өгч байгаа хүмүүсийн дийлэнх нь УИХ-ын гишүүн халх байвал зүгээр гэж хариулжээ.

Зураг 8. УИХ-д байх гишүүний үндэс, угсаа




Судалгаанд оролцогчдын 82.8% нь халх үндэс, угсаатай байна. Эдгээр хүмүүсийг 100% гэж үзэж, ямар үндэс, угсаатай хүн УИХ-ын гишүүн байвал зохимжтой талаар тодруулахад 52.2% нь халх гэж хариулсан бол 47% нь ямар үндэс, угсаатай байх нь чухал биш гэсэн байр суурийг илэрхийлжээ.

УИХ-д байх гишүүний зан чанар. УИХ-ын гишүүн хүн нь үнэнч, шударга байх ёстой гэж судалгаанд оролцогчдын 70%-80% нь хариулсан нь хамгийн өндөр дүн байна. Мөн амлалтдаа хүрдэг, ёс зүйтэй, нийтийн сайн сайхны төлөө сэтгэлтэй, шулуухантай зантай байх нь чухалд тооцогдож байна. УИХ-ын эмэгтэй гишүүн нь алдаагаа хүлээн зөвшөөрдөг, аливааг эергээр хардаг, эрэгтэй гишүүн нь шулуухан зантай, ёс зүйтэй байх шаардлагатай гэжээ.

УИХ-д байх гишүүний гадаад төрх. УИХ-ын гишүүн нь гадаад төрхийн хувьд эрүүл чийрэг, зөв царайны төрхтэй, монголжуу царайтай, зөв хувцасладаг байх шаардлагатай гэж судалгаанд оролцогчид үзэж байна. УИХ-ын эрэгтэй, эмэгтэй гишүүний гадаад төрхөд тавигдаж буй шаардлагын ялгаатай байдлаас харвал эмэгтэй гишүүн бусдыг татах чадвартай (харизм), царайлаг, эрэгтэй гишүүн илүүдэл жингүй байх нь чухал гэжээ.

Зураг 9. УИХ-д байх гишүүний гадаад төрх



Тайлбар: Нэг хүн 3 хүртэлх хариулт өгсөн тул нийлбэр 100% барихгүй болохыг анхаарна уу.

УИХ-д байх гишүүний гэр бүлийн байдал. УИХ-ын гишүүний гэр бүлийнх нь хүн заавал Монгол хүн байх ёстой гэж судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь үзэж байгаа бол өөр улсын иргэн байж болно гэж хүлээн зөвшөөрсөн байдал маш бага дүнг эзэлж байна. Ер нь УИХ-ын гишүүний гэр бүлийн хүн аль улсынх байх нь чухал биш гэж судалгаанд оролцогчдын 47% хариулсан бол эрэгтэй эсвэл эмэгтэй гишүүн байхаас шалтгаалж энэ үзүүлэлт 32%-38% болж буурчээ.

УИХ-д байх гишүүний намын харьяалал. Судалгаанд оролцогчдын 54%-61%, өөрөөр хэлбэл хамгийн багадаа 2 хүн тутмын нэг нь УИХ-ын гишүүний намын харьяалал чухал биш гэж үзэж байгаа бол 12%-14% нь намын харьяалалгүй, улс төржөөгүй орчинд ажиллах нь чухал гэж үзэж байна. УИХ-ын гишүүнийг сонгохдоо

улс төрийн намын харьяалалд дунджаар 3 хүн тутмын нэг нь ач холбогдол өгөхөөр байна. Нам бус хүмүүсийн 61.2%, намын гишүүдийн 46.7% нь намын харьяалал чухал биш гэж хариулжээ. Энэ нь нам бус хүмүүс намын гишүүдтэй харьцуулахад УИХ-ын гишүүний намын харьяалалд ач холбогдол бага өгдөг болохыг харуулж байна.

Зураг 10. УИХ-д байх гишүүний намын харьяалал
(Намын гишүүнчлэлтэй эсэхээр)



УИХ-д байх гишүүний шашин шүтлэг

УИХ-ын гишүүн ямар шашинд итгэж, сүсэглэдэг байх нь чухал биш гэж судалгаанд оролцогчдын 60% орчим нь үзэж байна.

Харин шашинд ач холбогдол өгч буй бүлгийн мэдээллээс харвал иргэдийг төлөөлж УИХ-д байх гишүүн буддын шашинд итгэж, сүсэглэдэг байвал зүгээр гэсэн байр суурийг илэрхийлж байна. Удаах хүлээн зөвшөөрч буй нь бөөгийн шашин аж. Судалгаанд оролцогчдын 46.2% нь ямар нэг шашинд итгэдэггүй, 52.2% нь шашинд итгэдэг байна. Энэ үзүүлэлтийг задлан харуулбал, Христийн шашинд итгэдэг хүмүүсийн 40%, Буддын шашинд итгэдэг хүмүүсийн 56.6%, шашин итгэдэггүй хүмүүсийн 79.7% нь УИХ-д сонгогдох хүн нь ямар шашинд итгэж, сүсэглэдэг байх нь чухал биш гэж үзжээ.

УИХ-ын гишүүн болох хүн нь Буддын шашинд итгэж, сүсэглэдэг байвал зүгээр гэж буддын шашинд итгэгчдийн 39.2 хувь, шашинд итгэдэггүй хүмүүсийн 10 хувь буюу дийлэнх нь хариулсан. Харин Христийн шашинд итгэдэг хүмүүсийн 26.7% нь УИХ-д сонгогдох хүн Христийн шашинд итгэж сүсэглэдэг байвал зүгээр байна гэв.

Хүснэгт 1. УИХ-д байх гишүүний шашин шүтлэг

УИХ-д байх гишүүний шашин, шүтлэг	Сонгогчийн шашин, шүтлэг		
	Христийн шашинд итгэдэг	Буддын шашинд итгэдэг	Шашинд итгэдэггүй
Христийн шашин	26.7%	1.4%	0.4%
Исламын шашин	-	0.5%	-
Буддын шашин	13.3%	39.2%	10%
Мүүний шашин	-	0.5%	-
Бөөгийн шашин	-	2.8%	1.7%
Ямар шашинд итгэж, сүсэглэдэг байх нь чухал биш	40%	56.6%	79.7%
Хэлж мэдэхгүй байна	13.3%	6.6%	9.5%
Бусад			0.9%
Шашинд итгэж, сүсэглэдэггүй байх	6.7%	1.4%	1.7%

УИХ-д байх гишүүний төрж өссөн газар, үндэс угсаа

УИХ-ын гишүүн хаана төрж, амьдардаг байх нь чухал биш гэж хамгийн багадаа 2 хүн тутмын нэг нь хариулсан бол бусдад нь өсөж, төрсөн газар нь хамааралтай байдаг аж. Судалгаанд оролцогч 5 хүн тутмын нэг нь өөрийг нь төлөөлж УИХ-д байх гишүүн “надтай нэг нутагт төрсөн байх нь чухал” гэж хариулсан нь хамгийн өндөр байсан бөгөөд эрэгтэй, эмэгтэй гишүүн байхаас үл хамааран төдийлөн ялгаагүй байна.

УИХ-ын эмэгтэй гишүүнийг “манай нутагт төрөөгүй ч одоо оршин сууж, амьдардаг байх ёстой”, УИХ-ын эрэгтэй гишүүн “Монголдоо л төрсөн байхад болно” гэсэн шаардлага тавьж байгаа нь ялгаатай байдлыг илтгэж байна. Судалгаанд оролцогчдын 38.6% нь Улаанбаатар хотод, 7.6% нь Завхан аймаг, 5% нь Архангай аймаг, 4.8% нь Говь-Алтай аймагт, 44% нь бусад аймагт төрж, өссөн байна. Улаанбаатар хот, аймаг орон нутагт төрсөн эсэхээс үл хамааран дунджаар 10 хүн тутмын 6 нь өөрийг нь төлөөлж УИХ-д байх гишүүн хаана төрж, амьдардаг байх нь чухал биш гэж үзэж байна. Харин УИХ-ын гишүүний төрж, өссөн газрыг дунджаар 10 хүн тутмын 3 нь чухалчилж байна.

Улаанбаатар хот болон Говь-Алтай аймагт төрсөн хүмүүсийн хувьд өөртэйгөө нэг нутагт төрсөн хүмүүсийг дэмжих хандлага хамгийн өндөр байна. Харин Архангай аймагт төрсөн хүмүүсийн хувьд УИХ-ын гишүүн нь тухайн нутаг дэвсгэртээ амьдардаг байх нь чухал гэж хариулсан нь бусадтай харьцуулахад өндөр байсан болно.

Хүснэгт 2. УИХ-д байх гишүүний төрж, өссөн газар


		УИХ-д байх гишүүний төрж, өссөн газар							
		Надтай нэг нутагт төрсөн байх нь чухал	Манай нутагт төрөөгүй ч одоо оршин сууж, амьдардаг байх ёстой	Гадаадад амьдарч байсан	Монголдоо л төрсөн байхад болно	Бусад	Хаана төрж, амьдардаг байх нь чухал биш	Хэлж мэдэхгүй байна	Нийт
Сонгогчийн уугуул нутаг	Улаанбаатар хот	22%	5%	3%	5%	2%	61%	3%	100%
	Архангай	12%	16%	8%	8%	-	48%	8%	100%
	Говь-Алтай	21%	-	-	-	-	71%	8%	100%
	Завхан	18%	8%	-	11%	3%	58%	3%	100%
	Нийт	19%	9%	4%	8%	2%	59%	5%	100%

Хүснэгт 3. УИХ-д байх гишүүний төрж, өссөн газар

		УИХ-д байх гишүүний төрж, өссөн газар							
		Надтай нэг нутагт төрсөн байх нь чухал	Манай нутагт төрөөгүй ч одоо оршин сууж, амьдардаг байх ёстой	Гадаадад амьдарч байсан	Монголдоо л төрсөн байхад болно	Бусад	Хаана төрж, амьдардаг байх нь чухал биш	Хэлж мэдэхгүй байна	Нийт
Сонгогчийн уугуул нутаг	Улаанбаатар хот	22%	5%	3%	5%	2%	61%	3%	100%
	Архангай	12%	16%	8%	8%	-	48%	8%	100%
	Говь-Алтай	21%	-	-	-	-	71%	8%	100%
	Завхан	18%	8%	-	11%	3%	58%	3%	100%
	Нийт	19%	9%	4%	8%	2%	59%	5%	100%

УИХ-д сонгогдох хүний хөрөнгө, орлого. Судалгаанд оролцогч 3 хүн тутмын нэг нь УИХ-ын гишүүн хөрөнгөтэй байх эсэх нь чухал биш гэж үзэж байгаа бол 10 хүн тутмын нэг нь орлогын түвшинд ач холбогдол өгч байна. Орлогын хэмжээ дунд зэрэг буюу амьдралын наад захын хэрэгцээгээ асуудалгүй зохицуулчихдаг хүн УИХ-ын гишүүн болоход тохиромжтой гэж ойролцоогоор 10 хүн тутмын 4 нь хариулсан бол их хэмжээний орлоготой байх нь зөв гэж 10 хүн тутмын 5 нь хариулжээ.

Зураг 11. УИХ-д байх гишүүний орлого




УИХ-ын гишүүний орлогын хэмжээнд ач холбогдол өгч буй эсэхийг судалгаанд оролцогчдын хүйсээр харьцуулж харвал, эрэгтэй сонгогчид УИХ-ын гишүүний орлого дунд зэрэг байхад болно, эмэгтэй сонгогчид их хэмжээний орлоготой байх нь зөв гэж хариулсан нь өндөр байна.

Насны бүлгээр харьцуулж харвал, 25-32 настай 3 хүн тутмын нэг, 18-24 нас, 33-40 настай 4 хүн тутмын нэг нь УИХ-ын гишүүн нь их хэмжээний орлоготой байх хэрэгтэй гэж үзэж байгаа бол 41-ээс дээш насныхан орлогын түвшин нь дунд зэрэг байхад болно гэж үзэж байна.

Харин УИХ-ын гишүүн хөрөнгөтэй байх эсэх нь чухал биш гэж 18-24 нас, 33-аас дээш насны 3 хүн тутмын нэг нь хариулжээ.


Зураг 12. УИХ-д байх гишүүний орлого (хүйс, насны бүлгээр)



УИХ-ын гишүүний орлогын хэмжээнд ач холбогдол өгч буй эсэхийг ерөнхий байдлаар харвал хөрөнгөтэй байх нь чухал биш, орлого нь дунд зэрэг байхад хангалттай гэж үзэх нийтлэг хандлагатай байна.

Харин УИХ-ын гишүүн эмэгтэй байх тохиолдолд дунд зэрэг, эрэгтэй байх тохиолдолд их хэмжээний орлоготой байвал оновчтой гэсэн ялгаатай байдал ажиглагдаж байна.

Зураг 13. УИХ-д байх гишүүний орлого



IV. Дүгнэлт

Баянгол дүүргийн сонгогчид дараахь дүр төрх бүхий УИХ-ын гишүүнийг илүүд үзэж байна. Насны хувьд нийтлэг байдлаар гишүүн болох хүний насыг 36-55 хооронд, хүйсээр нь харвал эрэгтэй бол 45-55 нас, эмэгтэй бол 36-45 настай байх үр дүн гарсан. Үндэс угсааны хувьд халх болон ямар үндэс угсаатай байх нь чухал биш гэсэн хоёр сонголт нийтлэг байлаа. Гэхдээ эмэгтэй нэр дэвшигчийг халх байх нь чухал гэсэн үр дүн гарсан. Хувь хүний зан чанарын хувьд үнэнч шударга, амлалтдаа хүрдэг нийтийн сайн сайхны төлөө гэсэн сэтгэлтэй хүн байх нь чухал хэмээн сонгосон байна. Үр дүнг хүйсээр харвал эрэгтэй нэр дэвшигчийн хувьд шулуухан зантай, ёс зүйтэй байхыг, эмэгтэй нэр дэвшигчийн хувьд алдаагаа хүлээн зөвшөөрдөг, аливаад эергээр ханддаг зан чанартай байх хариулт давамгайл байна. Судлаач Киндэр (Kinder, 1980) “эрх мэдэлд шунамтгай”, “тогтворгүй” байдал нь манлайллын хамгийн сөрөг шинж бол “үнэнч шударга” байдал нь хамгийн эерэг хэв шинж гэж сонгогчид тооцдог гэсэн нь Баянгол дүүрэгт хийгдсэн судалгааны үр дүн нотлон харуулж байна.

Улмаар гадаад төрх нь эрүүл чийрэг, зөв царайны төрхтэй, монголжуу царайтай, зөв хувцаслах нь таалагддаг байна. Хүйсээр авч үзэхэд эрэгтэй хүний хувьд илүүдэл жингүй байх, эмэгтэй хүний хувьд бусдыг татах чадвартай байх нь чухал хэмээсэн байна.

Боловсролын хувьд эрэгтэй улс төрчийг доктор зэрэгтэй, эмэгтэй улс төрчийг магистр болон түүнээс дээш байхыг илүүд үзжээ. Боловсрол эзэмшсэн газар эрэгтэй хүний хувьд хаана боловсрол эзэмших нь чухал биш бол эмэгтэй улс төрчийн хувьд монголд гэж тодотгож байгаа нь сонирхол татахуйц байлаа. Мэргэжлийн хувьд эдийн засагч, хуульч, улс төр судлаач гэж нийтлэг байдлаар хариулсан байна. Хүйсээр харвал эрэгтэй хүний хувьд инженер, физикч, математикч гэсэн бол эмэгтэй хүний хувьд олон улсын харилцаа, багш гэсэн сонголт илүү байлаа. Мөн ажлын туршлагыг нийгэм эдийн засаг, улс төр, хууль зэрэг салбарын олон талын мэдлэгтэй байж мэргэжлээрээ олон жил ажилласан байхыг чухалчилсан.

Эрэгтэй хүний хувьд эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр ажилласан байхыг онцолсон. Харин эмэгтэйчүүдийн хувьд бизнесийн байгууллагад ажилласан байх нь давуу тал байхаар байна.

Ур чадварын хувьд манлайлагч, нөхцөл байдлыг хурдан ойлгож, улс төрийн шийдвэрийг мэргэжлийн түвшинд гаргах, задлан шинжилж, дүгнэх чадвартай байх нь чухал байна. Мөн хүйсээр харвал эрэгтэй улс төрч ажил хийх хүсэл эрмэлзэлтэй, шинийг санаачлагч, сэтгэл хөдлөлдөө автахгүй байхын чухлыг тодорхойлжээ. Эмэгтэй улс төрчийг шуурхай шийдвэр гаргах, багийн гишүүдээ сонсдог, хийсэн ажлаа олон нийтдэг хүргэдэг байхыг илүүд үзжээ.

Хувь хүний хувьд гэр бүлийн хүн нь заавал монгол байх ёстой гэсэн шаардлага эмэгтэй улс төрчийн зайлшгүй үзүүлэлт болж байна. Түүнчлэн намын харьяаллын хувьд эрэгтэй улс төрч намын харьяалал чухал бол эмэгтэй улс төрчийн хувьд намын харьяалал чухал биш гэжээ. Шашин шүтлэгийн хувьд буддын шашинтай байхыг хоёр хүйсээс чухалчилсан байна. Улмаар өсөж төрсөн газар нь монголдоо өсөж төрсөн байх нь чухал боловч эмэгтэй улс төрчийн хувьд чухал биш үзүүлэлт байлаа. Хамгийн чухал үзүүлэлт болох орлогын хувьд эрэгтэй нь их хэмжээний орлоготой байх, эмэгтэй хүний хувьд дунд зэрэг орлоготой байх ёстой хэмээн баянголчууд үзжээ.

Ашигласан материал

Стратеги академи. 2021; 2022. Нийгэм, улс төр, эдийн засгийн талаарх олон нийтийн санаа бодол. Уб.,

Түмэнцэцэг П. 2022. Монгол сонгогчийн зан үйл: нөлөөлөгч хүчин зүйлс, өөрчлөлт. Уб.,

Хэвлэл мэдээллийн зөвлөл. 2021. Мэдрэмжтэй мэдээлье. Уб.,